

**Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын дарга Б.Болдбаатар: Бодлогын хүүг нэмснээр орон сууцны үнийн өсөлтийг хазаарлана**

Монголбанкнаас бодлогын хүүг өсгөх шийдвэрт хүрснээ өчигдөр зарлалаа. Хүний хөгжил сангаас олгож буй бэлэн мөнгө, төсвийн өндөр зарлага, хувийн хэвшлийн эрэлт өссөн зэрэг нь инфляцийг нэмсэн хэмээн тэд ярих.

**-Гаргасан шийдвэрээ тайлбарлаж өгөөч. Бодлогын хүү нэмгэдсэнээр манай эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлөх вэ?**

-Монголбанкны захирлуудын зөвлөл хуралдаж, бодлогын хүүг 0.25 хувиар нэмэх шийдвэр гаргасан. Ингэснээр бодлогын хүү 11.75 хувь боллоо. Банкуудын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг хоёр хувиар нэмэгдүүлж 11 хувь болгох шийдвэр гаргалаа.

**-Яагаад ийм шийдвэр гаргав?**

-Инфляц өсч байгаагаас ийм шийдвэр гаргахаас аргагүй байлаа. Үндэсний статистикийн хорооны өнгөрсөн сарын мэдээллээр инфляц улсын хэмжээнд 5.1, нийслэлийн хэмжээнд 11.4 хувь болж өссөн байна. Хүний хөгжлийн сангаас олж байгаа их хэмжээний бэлэн мөнгө, төсвийн их зарлага, хувийн хэвшлийн эрэлт өссөн нь нийт эрэлтийг өсгөж, төрийн зохицуулалттай зарим барааны үнэ нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас сүүлийн таван сарын турш инфляц 12 хувьд хүрсэн. Энэ эрэлт нь энэ оны сүүл, ирэх оны хагас хүртэл үргэлжлэх төлөвтэй байгаа. Бас шатахууны үнэ өссөнөөр тээврийн зардал ч нэмэгдэж, энэ нь цаашлаад бусад барааны ханшийг өндөрсгөх төлөвтэй байна. Монголбанкнаас ийм шийдвэр гаргасан нь санхүүгийн салбарыг бат бөх байлгах, иргэдийн амьжиргааг инфляцид дарамтлуулахгүйн тулд юм.

**-Бодлогын хүү ингээд өсөөд л байх уу. Цаашдаа яах бол?**

-Төсвийн бодлого хэрхэн хэрэгжих, эдийн засгийн дэд бүтцийг хэрхэн бий болгохтой бодлогын хүү буурах эсэх нь их холбоотой болоод байна. Бидний харж байгаагаар ДНБ-ийн өсөлт нэлээд хүчтэй нэмэгдэж байгаа. Ингэж нэмэгдэж байгаа үед эдийн засгийн үндсэн суурь дэд бүтэц, зам, энергийн эх үүсвэрийн өсөлтүүд төдийлөн мэдэгдэхгүй байна. Ялангуяа, хэмжээ томтой барааны импорт лут өсөлттэй байна. Тэгэхээр эдийн засгийн өсөлтийг боомилж байгаа суурь дэд бүтцийн асуудлыг хэр хурдан шийдэхээс бодит өсөлтийн боломжийг бүрэн ашиглаж чадах уу гэдэг нь шалтгаална. Дэд бүтцийн өсөлт бий болохгүй бол боломжууд маань зөвхөн үнийн өсөлт болоод хувирчихна. Тиймээс л бидэнд бодлогын хүү бууруулах нөхцөл болохгүй.

**-БНСУ-ын Төвбанкны ерөнхийлөгч манай улсад айлчлахдаа “Засгийн газар, Төвбанкны бодлогын уялдаагүйгээс гарах үр дагавар нь ард түмний нуруун дээр үнийн өсөлт болон ирж байна” гэж мэдэгдсэн. Гэтэл Засгийн газар зардлаа өсгөсөөр, харин та бүхэн үүнээс үүсэх инфляцтай тэмцэхийн тулд бодлогын хүүгээ чангарууллаа. Засгийн газарт хандаж мэдэгдэл хийх зэргээр бодлогоор уялдуулалгүйгээр шууд хүүгээ өсгөх нь зөв алхам мөн үү?**

-Засгийн газар энэ бүхнийг хангалттай мэдэж байгаа гэж бодож байна. Сонгууль ойртож байна, улс төрийн сонголтууд ч хүчтэй байна. Эдийн засгийн боломжид садаа болохгүйгээр мөнгөний бодлого хэрэгжүүлэх нь чухал байна. Гэтэл нөгөө талдаа нийгмийн амьжиргааг хамгаалах өдөр тутмын ажлаа Монголбанк хийх ёстой.

**-Бодлогын хүү өсгөсөн нь банкуудын зээлийн хүүд хэрхэн нөлөөлөх вэ. Өмнө нь бодлогын хүү 14 хувьд хүрэхэд банкууд зээл олголтгоо ихээхэн хумьсан шүү дээ?**

-Бодлогын хүү өсгөж ирээдүйд гарч болзошгүй эрсдэлээс санхүүгийн зах зээлээ хамгаалах нь хамгийн чухал алхам болоод байна. Одоо бид ингэж инфляцийг барихгүй тохиолдолд зээлийн хүү бүр ихээр нэмэгдэж болзошгүй. Тэр эрсдэлээс л бид хамгаалж байгаа юм.

**-Тэгвэл хэдий хугацааны дараа зээлийн хүү буурах вэ?**

-Хамгийн хэцүү, боломжгүй зүйл бол хугацаа хэлэх явдал. Гэхдээ бодлогын хүүг өсгөх замаар инфляцийг барьснаар ирээдүйд гарч болох үнийн хэт өсөлт, ард иргэдийн өдөр тутмын амьжиргааг хамгаалах арга хэрэгсэл нь болно.

**-Өнгөрсөн долоо хоногт шинэ орон сууцны үзэсгэлэн худалдаа болсон. Банкууд ч зээлээ их танилцуулж байсан. Харин одоо бодлогын хүү нэмэгдчихээр орон сууцны зээлийн хүүг өсгөх юм биш үү. Залуу хосууд орон гэртээ болох монгол мөрөөдлөө хойш тавихад хүргэх юм биш байгаа?**

-Тийм сүрхий нөлөө үзүүлэхгүй. Орон сууцны хүртээмжтэй байдалд хоёр зүйл нөлөөлдөг. Орон сууцны үнэ тогтвортой байх ёстой, бас өрхийн бодит орлого өсч байх учиртай. Ингэсэн цагт орон сууцны хүртээмж, монгол мөрөөдлүүд биеллээ олох ёстой.

**-Таныхаар бодлогын хүү орон сууцны зээлийн хүүд нөлөөлөхгүй гэсэн үг үү?**

-Бодлогын хүүгээ бид нэмэхгүй, инфляцийг тоохгүй өндөр хэвээр нь явуулвал орон сууцны үнэ ч хурдан өснө, иргэдийн бодит орлого ч буурна. Ингэснээр орон сууцны хүртээмж буурна. Монгол мөрөөдөл маань улам л холдоно.

**-Та миний асуултад бүрэн хариулсангүй. Орон сууцны зээлийн хүүд нөлөөлөхгүй гэж Та хэлж чадах уу?**

-Зээлийн хүүд нөлөөлөх нөлөөлөл нь хязгаарлалттай байх байх.

**-Ямар хязгаарлалттай вэ?**

-Тооцооны хувьд дараагийн сарын инфляцийг судалж байж илүү нарийн тооцоог хэлэх боломжтой. Зээлийн хүүд шууд нөлөө үзүүлэхгүй.